

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2026-2028 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ДҮГНЭЛТ

2025.05.22

Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх Эдийн засгийн зөвлөл нь ээлжит хэлэлцүүлгээ Монгол Улсын Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу Засгийн газраас боловсруулж УИХ-д өргөн барьсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг”-ийн төслийн асуудлаар 2025 оны 5 дугаар сарын 22-нд хийлээ. Зөвлөлөөс хууль тогтоогчдод хандан дараах санал, зөвлөмжийг өгч байна.

1. Өрийн удирдлагын стратегийн хамрах хүрээг тэлэх, өрийн нэгдсэн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох

- **Стратегийн баримт бичгийн агуулга, нэршлийг өөрчлөх:** Засгийн газрын өр гэдэгт нь өрийн хэрэгслээр үүсгэсэн засгийн газрын өөрийн өр, өрийн баталгаа, орон нутгийн өрийг ойлгохоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан байдаг. Харин олон улсад нийтийн салбарт өрийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ public debt буюу төрийн өр гэх өргөн хүрээнд авч үздэг сайн туршлага бий. Төрийн өр нь зөвхөн Засгийн газрын өрөөр хязгаарлагдахгүй бөгөөд төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, Төв банкны өрийг багтаадаг. Төрийн өрийн цар хүрээг цогцоор нь хянаж удирдахгүй бол далд, баталгаат бус өрийн дарамт нэмэгдэж эдийн засгийн тогтвортой байдалд заналхийлэх эрсдэлтэй.

Иймд стратегийн баримт бичгийн нэрийг “Төрийн өрийн удирдлагын стратегийн баримт бичиг болгон” өөрчилж агуулга, хамрах хүрээ, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох хуулийн нэмэлт шаардлагатай байна.

- **Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн** хувьд одоогоор 1 жилээс дээш хугацаатай, Засгийн газрын баталгаа, батлан даалт бүхий өр зээлийг Засгийн газрын өрийн удирдлагын хүрээнд хамруулдаг. Гэтэл оффтэйк гэрээ, борлуулалтын урьдчилгаа, төсвийн шинжтэй төсөл хэрэгжүүлэх ажлын төлбөр гэх мэт их хэмжээний өр төлбөр далд хэлбэртэй, хяналт сул байна. Тиймээс төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өрийн тодорхойлолтыг өргөтгөн стратегийн баримт бичгийн хүрээнд удирдах нь зүйтэй.
- **Нийслэл хот богино хугацаат, өндөр хүүтэй** бондыг гадаад, дотоод зах зээлд гаргасан нь 2026-2027 онд эргэн төлөлтийн өндөр дарамт үүсгэхээр байна. Нийт 2.5 орчим их наяд төгрөгийн нэрлэсэн дүн бүхий эдгээр зээлээр хэрэгжүүлэх төслийн үр өгөөж, эргэн төлөх эх үүсвэр, хуваарь зэрэг тодорхойгүй асуудал их, мэдээлэл нээлттэй бус байна.

2. Гадаад эрсдэлийн удирдлагыг сайжруулах

- **Ханшийн эрсдэл:** 2024 оны байдлаар нийт өрийн 96% нь гадаад валютаар байна. Валютын ханшийн огцом савлагаа өрийн үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх тул ханшийн богино, дунд хугацаанд хеджинг стратеги

хэрэгжүүлэх, урт хугацаат өрийн валютыг төрөлжүүлэх, нэн ялангуяа төгрөгийн зээлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

- **Олон улсын нөхцөл:** Олон улсын эдийн засгийн байдал тогтворгүй, инфляц өндөр хэвээр, АНУ зэрэг тэргүүлэх орнуудад бодлогын хүү өссөн, эрсдэлийн нэмэгдэл (risk premium) өсөж байгаа зэрэг хүчин зүйлийн улмаас гадаад зах зээлээс хөрөнгө татах өртөг өндөр болж байна. Иймд Засгийн газрын гадаад үнэт цаас гаргалтыг эдийн засгийн мөчлөгтэй уялдуулах зэрэг тодорхой стратегийг баримтлах шаардлагатай байна.

3. Ашигт малтмалын хамаарлыг бууруулах, төсвийн тогтвортой байдлыг хангах

- **Төсвийн орлогын эмзэг байдал:** Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах үед орлого огцом буурдаг цикл рүү Монгол Улс ороод байна. Иймд Төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагыг (тэнцвэржүүлсэн тэнцэл, орлогын тооцоолол, зарлагын өсөлтийн хязгаарлалт) анхны утгаар нь эргэн сэргээж төсвийн сахилга, тогтвортой байдлыг бэхжүүлэх нь зүйтэй.
- **Эдийн засгийн төрөлжилт:** Өрийг зөвхөн уул уурхайгаас хамааралтай эх үүсвэрээр биш, боловсруулалтын болон нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг дэмжих замаар санхүүжүүлэх урт хугацааны стратегийг боловсруулан хэрэгжүүлэх.

4. Санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх

- **Дотоодын өрийн хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх:** Дотоод үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлж, эрсдэлгүй хүүгийн суурь тогтоох, урт хугацаат, эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл бий болгох зорилгоор Засгийн газрын дотоодын бондыг нэмэгдүүлэх. Ингэхдээ Засгийн газрын үнэт цаас нь хүүг хөөрөгдөж, хувийн хэвшлийн санхүүжилтийн өртгийг нэмэгдүүлж байсан өмнөх алдааг давтахгүй байх, мөн зөвхөн банкууд бус иргэд, дотоодын жижиг хөрөнгө оруулагчид (retail investors) оролцох боломжийг нэмэгдүүлэх.
- **Төр-Хувийн хэвшлийн түншлэлийн (PPP) шинэлэг загваруудыг** хэрэглэж төсвийн богино хугацаат өр төлбөрийг нэмэгдүүлэхгүй байх урт хугацааны түншлэлийн загваруудаар дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

5. Ил тод байдал ба мэдээллийн нэгдсэн сан

- **Өрийн зориулалт, үр ашиг:** Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн ТЭЗҮ-ийг нээлттэй болгож, хөрөнгө зарцуулалтын үр ашгийг тогтмол үнэлэх механизм бүрдүүлэх.
- **Бүртгэл ба мэдээлэл:** Сангийн яам, Монголбанк, орон нутгийн өрийн бүртгэл, тайланг нэгдмэл системд шилжүүлж, өрийн мөнгөн урсгалын нарийвчилсан мэдээллээр баяжуулан ил тод нийтлэх.

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН ДЭРГЭДЭХ
ЭДИЙН ЗАСГИЙН ЗӨВЛӨЛ